



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 505

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын театрын музейн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй, 8 нэрийн, нийт 4,124,834.96 (дөрвөн сая нэг зуун хорин дөрвөн мянга найман зуун гучин дөрвөн төгрөг ерэн зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, Монголын театрын музейн захирал Д.Наранжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ



13300203

22-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын тазрын
2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт



МОНГОЛЫН ТЕАТРЫН МУЗЕЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
					(төгрөг)		
Тавилга эд хогшил							
1	Үзмэрийн шар шкаф	2/25/2006	ш	1	216,538	216,538.00	0.00
2	Суурьтай намхан шилэн хорго	5/25/2012	ш	6	28,267	169,599.96	0.00
3	Шилэн хорго	11/25/2013	ш	2	510,000	1,020,000.00	0.00
4	Сандаал хар	5/25/2012	ш	4	119,900	479,600.00	0.00
5	Чийг дулаан хэмжигч	8/15/2013	ш	1	382,647	382,647.00	0.00
6	Гэрэл зургийн жааз	1/1/2018	ш	50	25,000	1,250,000.00	0.00
	Тавилга эд хогшлын дүн			64		3,518,384.96	
Бусад үндсэн хөрөнгө							
7	Тоос сорогч 930	3/19/2019	ш	1	269,990	269,990.00	0.00
8	Зөөврийн хард диск	3/1/2014	ш	1	336,460	336,460.00	0.00
	Бусад үндсэн хөрөнгийн дүн			2		606,450.00	0.00
	НИЙТ ДҮН			66		4,124,834.96 (дөрвөн сая нэг зуун хорин дөрвөн мянга найман зуун гучин дөрвөн төгрөг ерэн зургаан мөнгө)	0.00